

ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

NEWSLETTER

МАНДАХ ИХ СУРГУУЛЬ НЬ ACBSP БАЙГУУЛЛАГААР 10 ЖИЛЭЭР 2 ДАХЬ УДААГАА МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДЛЭЭ

ACBSP байгууллагын 2024 оны хурал нь АНУ-ын Майами хотод 2024 оны 6 сарын 27-30 өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд Мандах их сургууль нь ACBSP байгууллагаар 10 жилээр 2 дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн гэрчилгээгээ албан ёсоор ёслол төгөлдөр гардан авлаа.

Магадлан итгэмжилсэн тухай гэрчилгээг сургалт эрхэлсэн проректор Ч.Төрбадрах, Сургалтын албаны ахлах ажилтан Б. Батцэцэг нар нь хүрэлцэн очиж, гэрчилгээг хүндэтгэлтэйгээр хүлээн авлаа.



Үйл явдлууд

Мандах их сургууль 2023 оны “Шилдэг түнш байгууллага”-аа тодрууллаа.

Мандах их сургууль нь 90 гаруй дотоодын байгууллагатай сургалт, семинар улсын хэмжээний олимпиад, уралдаан, тэмцээн, эрдэм шинжилгээний хурлыг хамтран зохион байгуулах, оюутны тэтгэлэгт хөтөлбөр зарлах, оюутны танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын ажлыг зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгохтой холбоотой санал санаачлагыг хэлэлцэх чиглэлээр хамтран ажилладаг.

Өнгөрсөн жилээс эхлэн Мандах их сургууль хамтрагч байгууллагуудаа урамшуулж, жил бүр оны “Шилдэг түнш байгууллага”-аа шалгаруулдаг уламжлал бий болсон. Хамтын ажиллагааны хүрээнд Мандах их сургуулийн төгсөгчдийг ажлын байраар хангасан байдал, дадлага хийлгэсэн байдал, оюутныг дэмжих төсөл хөтөлбөр болон тэтгэлэгт хөтөлбөрийг зарласан байдал зэрэг шалгуур үзүүлэлтээр 90 гаруй байгууллагаас Голомт банк 2023 оны “Шилдэг түнш байгууллага”-аар шалгарлаа. Голомт банк нь энэ хичээлийн жилээс Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийг Мандах их сургуультай хамтран хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэхүү хөтөлбөрт манай сургуулийн 36 оюутан хамрагдаж байна. Шагналыг Мандах их сургуулийн Ректор, Монгол Улсын Гавъяат багш, профессор Г.Нанжид, тус сургуулийн Магистрын хөтөлбөрийн төгсөлтийн баярын үеэр Голомт банкны Хүний нөөцийн удирдлагын газрын захирал Г.Уянгад гардууллаа. Мөн Мандах их сургууль болон Голомт банкны хамтын ажиллагааг өргөжин хөгжүүлэхэд хичээл зүтгэл, хүчин чармайлт гарган амжилттай ажилласан хувь нэмрийг үнэлж, Голомт банкны-ны Үйл ажиллагааны хэлтсийн захирал Д. Оюу-д “Талархал”, мөнгөн урамшуулал олгов.



Нягтлан бодох бүртгэлийн сургууль - бүртгэл шинжилгээний ТЭНХИМ ТӨЛӨВЛӨГӨӨТ ОЛИМПИАДУУДАА АМЖИЛТТАЙ ЗОХИОН

Оюутнуудын мэргэжлийн ур чадварын түвшин, мэдлэгийг дээшлүүлэх, оюутны бие даан суралцах идэвхийг өрнүүлэх зорилгоор Мандах Их Сургуулийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийн 1-4-р түвшний оюутнуудын дунд дараах олимпиадуудыг зохион байгууллаа.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДЭС ХИЧЭЭЛИЙН ОЛИМПИАД

Олимпиадыг Мандах Их Сургуулийн 2002 оны төгсөгч Д.Гантулга захиралтай Сити Ойл ХХК / City Oil LLC ивээн тэтгэж 2 төрлөөр 1-р түвшний 53 оюутны дунд зохион байгууллаа.

НББ хөтөлбөрийн 4-р түвшний оюутнуудын дунд анх удаа зохион байгуулагдсан тус олимпиад нь 2 үе шаттайгаар зохион байгуулагдлаа.

- 1-р үе шатанд 40 оюутан бүртгүүлж зохион байгуулагчдын бэлтгэсэн материалыг Google Sheet ашиглан бүртгэж, тайлагнасан.
- 2-р үе шатанд 16 оюутныг шалгаруулан Diamond санхүүгийн программ дээр ажилласан.

Олимпиадын үр дүн:

№	Нэр	Анги	Оноо	Байр
1	О.Хонгорзул	НББ-Аудит	8.68	1
2	Б.Анужин	НББ-Банк	7.84	2
3	Б.Алтанчимэг	НББ-Татвар	7.77	3
4	М.Ану	НББ-Англи хэл	7.14	Тусгай байр



Үйл явдлууд

Мандах их сургуульд олон улсын ACBSP магадлан итгэмжлэлийн байгууллагын шинжээч нар ажиллаж байна.

Мандах их сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн сургууль, Ахисан түвшний сургууль, Мэдээлэл технологийн сургууль Инженер, эдийн засгийн сургууль дээр Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллага (ACBSP)-ын шинжээч нар 2024.03.13-2024.03.15 өдрүүдэд ажиллаж байна. Мандах их сургууль нь сургууль болон хөтөлбөрүүдээ магадлуулахаар бэлтгэл хангасан байна.



Үйл явдлууд

Ахисан Түвшний Сургуулиас нийт докторантууддаа зориулж “Докторын зэрэг хамгаалуулах дүрэм” шинэчлэн батлагдсантай холбоотойгоор уулзалт зохион байгуулав.

Ахисан Түвшний Сургуулиас нийт докторантуудад “Докторын зэрэг хамгаалуулах дүрэм” шинэчлэн батлагдсантай холбоотойгоор уулзалтыг зохион байгуулж, Ахисан Түвшний Сургуулийн захирал, доктор, дэд профессор О.Бурмаа нь танилцуулгын дагуу мэдээллийг өгөв.

Уг уулзалтаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөл, дэд зөвлөлийн үйл ажиллагаа, докторын хөтөлбөр хэрэгжүүлж буй сургууль болон докторантаас шаардагдах асуудлуудыг хөндөж, докторантуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нь эрчимжүүлэх чиглэлийн асуудлуудыг ярилцаж, докторантууд өөр хоорондоо мэдлэгээ хуваалцлаа.



“Дусал цус дүүрэн амьдрал” донорын өдөрлөг боллоо

Монгол улсын Донорын тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн хүмүүнлэгийн үйл ажиллагааг дэмжин цусаа сайн дурын үндсэн дээр цус бэлэглэх “ДУСАЛ ЦУС ДҮҮРЭН АМЬДРАЛ” аяныг Цус сэлбэлт үндэсний төв, Баянгол дүүргийн Улаан загалмайн хороотой хамтран 2024 оны 02 сарын 27 ны өдөр зохион байгууллаа. Өдөрлөгт нийт 64 багш ажилтан, оюутнууд хамрагдан оролцож цусаа бэлэглэн эрдэнэт хүний амь нас аврах буянтай үйлс бүтээж нийт 22,5 литр цус хандивлалаа. Нэг хүний бэлэглэсэн цус бүрийг 3 хуваан цус цусан бүтээгдэхүүн болгосноор 220 хүнд амьдрал бэлэглэх боломжийг бүрдүүлсэн байна. Энэхүү аяныг нийгмийн хариуцлагын хүрээнд Мандах их сургуулийн багш ажилтан оюутнууд жил бүр тогтмол жилд 2 удаа тус аяныг дэмжиж оролцсоор ирсэн байна.



“Нягтлан бодох бүртгэлийн сайн дурын ажилтан клуб” 2023-2024 оны намрын улиралд ажилласан оюутнууддаа Батламжийг гардуулан өглөө.

Намрын улиралд зарлагдсан ажлуудад амжилттай ажиллаж төлөвлөгөөний дагуу ажлаа дуусгаж Батламж авах эрх үүссэн давтагдсан тоогоор 38 ажилтан ажиллалаа. Дээрх 38 ажилтнуудын ажилласан салбар нь үйлдвэрлэлийн салбарт 15, худалдаа, үйлчилгээний салбарт 5, Аудитын салбарт 12, татварын зөвлөх үйлчилгээний салбарт 1, Барилгын салбарт 3, Банк санхүүгийн салбарт 2 тус тус ажилласан байна.



Үйл явдлууд

Мандах Их Сургуулийн оюутны холбоо болж өргөжин бие даасан байгууллага болж гэрчилгээ, тамга тэмдгээ гардан авлаа.

Мандах Их Сургуулийн оюутнууд өөрсдийн эрхийг хамгаалах байгууллага байгуулж, сургуулийн захиргаатай хамтран ажиллах боломжийг бий болгож ирсэн. Сургууль байгуулагдсан эхний жилүүдэд “Ангийн дарга” нар, анги удирдсан багш нараараа дамжуулан сургуулийн захиргаатай холбогдон ажиллаж ирсэн бол 1998 онд “Оюутны зөвлөл”-ийг албан ёсоор байгуулж, энэхүү зөвлөлөөр дамжуулан сургуулийн захиргаатай хамтран ажиллах болсон. Оюутны зөвлөл нь 2024.04.01 ний өдөр Мандах Их Сургуулийн оюутны холбоо болж өргөжин бие даасан байгууллага болж гэрчилгээ, тамга тэмдгээ гардан авлаа.



Үйл явдлууд

БМИҮЗ-ийн шинжээчид “Бизнесийн удирдлага” магистрын хөтөлбөрийг хөндлөнгөөс үнэлж, магадлан итгэмжлэхээр манай сургууль дээр ажиллаж байна.

Мандах их сургуулийн Ахисан түвшний сургуулийн “Бизнесийн удирдлага” магистрын хөтөлбөрийг хөндлөнгөөс үнэлэхээр Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн шинжээчийн багийн бүрэлдэхүүн манай сургууль дээр 4 сарын 9, 10-ны өдрүүдэд ажиллаж байна.

Шинжээчийн багийн ахлагчаар БМИҮЗ-ийн шинжээч, доктор, профессор С.Эрдэнэтуул, гишүүдээр БМИҮЗ-ийн шинжээч, доктор, дэд профессор Л.Отгонжаргал, БМИҮЗ-ийн шинжээч, доктор, дэд профессор М.Халиун нар ажиллаж байна.




Үйл явдлууд

“Хиймэл оюун ухаанд суурилсан цахим боловсрол” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Мандах ИС нийт багш, ажилтнуудадаа хиймэл оюун ухааны орчин үеийн хэрэглээ, чиг хандлагын талаар “Хиймэл оюун ухаанд суурилсан цахим боловсрол” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.


Сургалтыг Монгол улсын Засгийн газар, БСШУ-ны яамны урилгаар Монгол Улсад айлчилж буй АНУ-н Меллон их сургуулийн хиймэл оюун ухааны бодлогын зөвлөх багш хадагтай Диксон Памела Грахам орлоо. Энэхүү сургалт нь бидний эрхэм зорилго Үндэсний болон Олон улсын стандарт, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой нэг үйл ажиллагаа болсон.



“Хиймэл оюун ухаанд суурилсан цахим боловсрол” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Мандах ИС нийт багш, ажилтнуудадаа хиймэл оюун ухааны орчин үеийн хэрэглээ, чиг хандлагын талаар “Хиймэл оюун ухаанд суурилсан цахим боловсрол” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Сургалтыг Монгол улсын Засгийн газар, БСШУ-ны яамны урилгаар Монгол Улсад айлчилж буй АНУ-н Меллон их сургуулийн хиймэл оюун ухааны бодлогын зөвлөх багш хадагтай Диксон Памела Грахам орлоо. Энэхүү сургалт нь бидний эрхэм зорилго Үндэсний болон Олон улсын стандарт, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой нэг үйл ажиллагаа болсон.



Үйл явдлууд

“Нягтлан бодох бүртгэлийн улсын 25 дугаар олимпиад Мандах Их сургуулийн төв байр, номын санд 2024.04.18-04.19-ны өдрүүдэд явагдаж байна.

Энэ жилийн олимпиад ММНБИ-ийн үүсгэн санаачлагчдын нэг, Монгол Улсын анхны шилдэг нягтлан бодогч, гавъяат эдийн засагч, Сүхбаатарын одонт Б.Осоргаравын нэрэмжит болж байна. Олимпиадад 9 сургуулийн 45 оюутан дараах 3 төрлөөр өрсөлдөж байна.

1. Онолын шалгалт
2. Шилдэг кэйс шалгаруулалт
3. Багийн кэйс шалгалт



№	Оролцогч сургуулиуд	Удирдагч багш	Хянагч багш
1	Мандах Их сургууль	Э.Энх-Амалан	С.Цэвээнжаргал
2	Санхүү Эдийн Засгийн Их	Э.Түвшинбаяр	Б.Бадрах
3	Хүмүүнлэгийн ухааны их	Т.Энхсайхан	
4	Хөдөө аж ахуйн их сургуулийн эдийн засаг	Э.Рэгзэндорж	Я.Нансалмаа
5	Олон улсын эдийн засаг	Т.Оюунтөгс	Л.Энхсайхан
6	Мандах Их сургуулийн	А.Шижирбаатар	Х.Одмандах
7	Орхон Их сургууль	Я.Шагдар	
8	Идэр Их сургууль	Э.Одончимэг	П.Гэрэлзаяа
9	Улаанбаатар Эрдэм Их	Н.Мөнхбаатар	

"БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ-2024" МАНДАХ ИХ СУРГУУЛЬ


4-р сарын 19-22 хүртэл Мишээл Экспо ОУУТанхимд "БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ-2024" Олон Улсын болон Дотоодын их дээд сургуулиудын нэгдсэн хамгийн том үзэсгэлэнд манай сургууль оролцож байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хүрэлцэн ирж Мандах Их Сургуулийн багш, оюутан нартай биечлэн уулзаж мэргэжил сонголтоо зөв хийхийг урьж байна.



Мандах их сургуулиас ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад зориулсан өдөрлөг зохион байгуулагдлаа.

Мандах их сургуулиас ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад зориулсан өдөрлөгт, Баянгол, Сонгинохайрхан дүүргийн сургуулиудын 200 гаруй сурагчид өдөрлөгт оролцлоо. Бүртгэл шинжилгээ тэнхим, Эдийн засаг бизнесийн тэнхим, Суурь шинжлэх ухаан инженерчлэлийн, Гадаад хэлний тэнхим, Компьютерын ухааны тэнхимийн багш оюутнууд сургууль болон хөтөлбөрүүдийг танилцуулж амжилттай зохион байгууллаа. Сурагчдын дунд тэнхимүүдийн нэрэмжит тэмцээн зохион байгуулагдаж гарын бэлэг гардуулан өглөө. Автобусаар үйлчилж, төгсөх ангийн сурагчдад мэргэжлээ хэрхэн



Үйл явдлууд

БМИҮЗ-ийн шинжээчид “Нягтлан бодох бүртгэл” магистрын хөтөлбөрийг хөндлөнгөөс үнэлж, магадлан итгэмжлэхээр манай сургууль дээр ажиллаж байна.

Мандах их сургуулийн Ахисан түвшний сургуулийн “Нягтлан бодох бүртгэл” магистрын хөтөлбөрийг хөндлөнгөөс үнэлэхээр Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн шинжээчийн багийн бүрэлдэхүүн манай сургууль дээр 4 сарын 25, 26-ны өдрүүдэд ажиллаж байна.

Шинжээчийн багийн ахлагчаар БМИҮЗ-ийн шинжээч, доктор, профессор Д.Далхжав, гишүүдээр БМИҮЗ-ийн шинжээч, доктор, профессор Д.Оюунцэцэг, БМИҮЗ-ийн шинжээч, ажил олгогчийн төлөөлөл М.Уранчимэг нар ажиллаж байна .



МЭРГЭШСЭН МЕНЕЖЕР бэлтгэх сургалтын хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээ амжилттай зохион байгуулагдлаа.

Мандах их сургууль болон Нэгдсэн Вант улсын Мэргэшсэн Менежментийн Институт / UK-Chartered Manager Institute/ -тай хамтран зохион байгуулах Мэргэшүүлэх, карьер өсөлт мэргэжил дээшлүүлэх **“Олон улсын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр”**-ийг оюутан залуус, багш ажилтнууддаа танилцуулж, нээлтийн арга хэмжээ зохион байгууллаа.

Chartered Manager Institute/CMI/ -нь 170 гаруй улсад гишүүнчлэлтэй “Мэргэшсэн менежер” цол олгох цорын ганц эрх бүхий байгууллага юм. Богино хугацаанд мэдлэг олж авах шалгалтгүй батламжийн сургалт, мэргэших түвшинд шат ахиулан суралцаж буйгаа батлах шалгалттай сертификатын сургалтыг CMI-аар хүлээн зөвшөөрөгдсөн Англи дахь “BBE training” сургалтын төвийн чадварлаг багш нараар заалган мэргэшсэн менежер болж, байгууллагадаа үнэ цэнтэй мэргэжилтэн болох боломжийг Мандах их сургууль нээж өгч байна.

Нээлтийн арга хэмжээнд “Оюуны ундраа пропертийз”-ийг үүсгэн байгуулагч О.Тэнүүн оролцож, мэргэшсэн менежер хүн байгууллагадаа хэр чухал байдаг, хэрхэн яаж үнэ цэнийг бий болгодог тухай сонирхолтой ярилцлагыг оюутан залуустай хийлээ.



Үйл явдлууд

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны мэдлэг олгох 45 хоногийн зэргийн бус сургалтын 3-р ээлжийн суралцагчид сертификатаа гардан авлаа.

2023-2024 оны хичээлийн жилийн 3-р ээлжийн сургалтыг амжилттай төгссөн 23 суралцагчдад сертификатыг гардуулан өглөө. Суралцагчид 180 цагийн 6 модуль хичээлийг үзэж төгслөө.



Үйл явдлууд

БМИҮЗ-ийн шинжээчид “Санхүү” магистрын хөтөлбөрийг хөндлөнгөөс үнэлж, магадлан итгэмжлэхээр манай сургууль дээр ажиллаж байна

Мандах их сургуулийн Ахисан түвшний сургуулийн “Санхүү” магистрын хөтөлбөрийг хөндлөнгөөс үнэлэхээр Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн шинжээчийн багийн бүрэлдэхүүн манай сургууль дээр 5 сарын 2, 3-ны өдрүүдэд ажиллаж байна.

Шинжээчийн багийн ахлагчаар БМИҮЗ-ийн шинжээч, доктор, профессор З.Ядмаа, гишүүдээр БМИҮЗ-ийн шинжээч, доктор, дэд профессор Л.Оюунцэцэг, БМИҮЗ-ийн шинжээч, ажил олгогчийн төлөөлөл Б.Алтантуяа нар ажиллаж байна.



МАНДАХ ИХ СУРГУУЛЬД БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ISO21001:2018 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛСЭН САЙН ТУРШЛАГА ХУВААЛЦАХ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Мандах ИС-ийн ББМТ-ны ISO21001:2018 стандартын шалгуур шаардлага, баталгаажуулалтын талаар мэдээлэл хүргэх, түүнийг нэвтрүүлэх арга зам, хэрэгжүүлж буй сайн туршлага, ач холбогдолын талаар мэдлэгээ хуваалцах зорилготой үйл ажиллагааг ЧУЗА-аас зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаанд Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тохирлын үнэлгээний “Эс Эф Си Эс” ХХК, Стандартын зөвлөх үйлчилгээний AMU консалтинг компаниуд дэмжин оролцлоо. ОУ-ын ISO21001 стандартын чиглэлээр сонирхолтой, практик ач холбогдолтой, чанарын баталгаажуулалтын шинэ санааг дэвшүүлсэн, орчин үеийн чиг хандлагын талаар мэдээлэл хүргэсэн илтгэлүүд хэлцэгдэв. Үүнд:

1. “Менежментийн тогтолцооны стандартын тухай” сэдвээр - AMU консалтинг компани захирал, тэргүүлэх аудитор Д.Дуламсүрэн
2. Мандах ИС-ийн ББМТ-ны ISO21001:2018 стандартыг нэвтрүүлсэн туршлага, ач холбогдол – Чанарын удирдлага зохицуулалтын албаны дарга П.Болормаа
3. “ ISO 21001 стандарт ба Боловсролын магадлан итгэмжлэл” - G2G сургалтын төвийн ISO 21001 стандартын тэргүүлэх аудитор, сургагч багш, зөвлөх Ж.Тунгалаг
4. Стандартын баталгаажуулалтын үйл ажиллагаа, түүний онцлог – “Эс Эф Си Эс” ХХК -ийн гүйцэтгэх захирал ISO9001 стандартын тэргүүлэх аудитор Г.Ундаръяа

Энэхүү уулзалт, семинарт 21 их, дээд сургуулийн удирдлага, чанарын баталгаажуулалтын хариуцсан мэргэжилтэн, арга зүйч, багш 46 хүн хүрэлцэн ирж, оролцогчид сэтгэл ханамжтай үр дүнтэй үйл ажиллагаа боллоо.



Мандах их сургуулийн 1, 2-р түвшний оюутнуудад гадаадын их дээд сургуультай хамтран хэрэгжүүлж байгаа оюутан солилцоо, хос диплом олгох хөтөлбөр болон хамтарсан 2+2 хөтөлбөрийн талаарх танилцуулах уулзалт хийлээ

Мандах их сургуулийн 1, 2-р түвшний оюутнуудад гадаадын их дээд сургуультай хамтран хэрэгжүүлж байгаа оюутан солилцоо, хос диплом олгох хөтөлбөр болон хамтарсан 2+2 хөтөлбөрийн талаар танилцуулах уулзалтыг 2024 оны 5-р сарын 09-ний өдөр зохион байгуулав. Уулзалтанд Мандах их сургуулийн Сургалт эрхэлсэн проректор Ч. Төрбадрах оролцож, тус сургуультай хамтын ажиллагаатай гадаадын их дээд сургуулийн хамтарсан хөтөлбөрүүдэд манай оюутнууд хэрхэн оролцож болох талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгөв. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны ажилтан З.Булганаа Мандах их сургуультай хамтын ажиллагаатай ажилладаг гадаадын их дээд сургуулиудын мэдээлэл болон Швейцарын Эдийн засаг, технологийн их сургуультай хамтран хэрэгжүүлдэг Хос диплом олгох хөтөлбөрийн талаар танилцуулга хийсэн бол Эдийн засаг, бизнесийн тэнхимийн доктор багш Т.Ганхуяг БНСУ-ын Чонжу их сургууль болон Самён их сургуультай хамтран хэрэгжүүлэх 2+2 хөтөлбөр, Гадаад хэлний тэнхимийн багш Т.Оюун-Эрдэнэ БНСУ-ын Намсүүл их сургуультай хамтран хэрэгжүүлэх 2+2 хөтөлбөрийн танилцуулгыг тус тус хийлээ.



СДШНББ-ИЙН МИНИ ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах Их Сургуулийн нягтлан бодох бүртгэл хөтөлбөрийн 2-р түвшний оюутнуудын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг СДШНББ-ийн мини олимпиад 2024.05.16-нд зохион байгуулагдлаа. Тус олимпиадад төв сургуулийн өдрийн ангийн 2-р түвшний 33 оюутан, МИС-Дархан салбарын 2-р түвшний 16 оюутан нийт 49 оюутан оролцож, эхний гурван байранд хувийн дүнгээр дараах 3 оюутан шалгарлаа.

№	Овог	Нэр	Анги	Оноо	Байр
1	Базарсад	Батцэцэг	НББ-Татвар	55.50	I
2	Баасандамба	Номундарь	Дархан салбар сургууль	53.50	II
3	Баттулга	Төгөлдөр	НББ-Банк	50.50	III



2023-2024 оны Шилдэг оюутан, шилдэг хамт олон, шилдэг клубыг шалгарууллаа

2024.05.16-нд Мандах Их Сургуулийн Үүсгэн байгуулагдсан өдрийг тохилдуулан шилдэг оюутан, шилдэг хамт олон, шилдэг клубийг шалгаруулдаг уламжлалтай билээ. Энэхүү өдөр сурлагаар тэргүүлэгч шилдэг оюутан, эрдэм шинжилгээ судалгааны ажлаар тэргүүлэгч шилдэг оюутнуудыг тус тус шагнав. Мөн тус өдөр сургуулиа төлөөлөн олон улсын уралдаан тэмцээн, олимпиадад амжилттай оролцсон оюутнуудыг шагнаж урамшуулав. Амжилт гаргасан баг хамт олон Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн 24-р улсын олимпиад багийн төрөлд тэргүүн байр

Хүний нөөцийн менежментийн улсын XIII олимпиад багийн төрөлд 3-р байр

Ирээдүйн аудитуудын сорилго-2023” олимпиад багийн тэргүүн байр

Сурлагаар тэргүүлэгч шилдэг оюутан – НББ-Татвар 4-р түвшний оюутан Б. Энхбаясгалан

Эрдэм шинжилгээ судалгааны ажлаар тэргүүлэгч шилдэг оюутан

НББ-Татвар 4-р түвшний оюутан З. Түшигмаа

Урлаг, спортоор тэргүүлэгч оюутан

НББ-Татвар 4-р түвшний оюутан О.Анар

3-р түвшний Шилдэг анги хамт олноор

Нягтлан бодох бүртгэл -Татвар хөтөлбөр

4-р түвшний Шилдэг анги хамт олноор – Нягтлан бодох бүртгэл -Татвар хөтөлбөр

Шилдэг клуб, дугуйлан – Мандах Мазаалай сагсан бөмбөгийн дугуйлан



Олон улсын ACBSP байгууллагаас Мандах их сургуулийг амжилттай магадлагдсан тухай албан ёсны шийдвэрийг ирүүллээ

Мандах их сургууль нь 2014 онд ACBSP байгууллагаар 10 жилийн хугацаатай амжилттай магадлан итгэмжлүүлсэн ба 2024 онд дараагийн 10 жилийн магадлан итгэмжлэлийн Өөрийн үнэлгээний тайланг бичиж, тус байгууллагад хүргүүлсэн билээ. 2024 оны 3-р сард ACBSP -ын шинжээчид манай сургууль дээр ажиллаж, холбогдох нотлох баримтуудтай танилцсан бөгөөд 2024 оны 4-р сарын 22-23-ний өдрүүдэд хуралдсан ACBSP-ын Комиссын Зөвлөлийн хурлаас Мандах их сургуулийн **байгууллага** болон **хөтөлбөрүүд** ACBSP-ын шалгуур шаардлагыг бүрэн хангасан байна гэж үзэж, дахин 10 жилээр магадлан итгэмжилсэн тухай шийдвэрийг гаргасан байна.

ACBSP байгууллагын журмын дагуу 2 жил тутам ахиц дэвшлийн тайланг ACBSP-д хүргүүлнэ.

Байгууллага болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн Өөрийн үнэлгээний тайлан бичиж, амжилттай хамгаалсан ажлын хэсгийн дарга болон гишүүд, дэмжиж ажилласан хамт олондоо баяр хүргэж, талархал дэвшүүлье.

Сургуулийн захиргаа



“ӨРТГИЙН БҮРТГЭЛ” ХИЧЭЭЛИЙН ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Бүртгэл шинжилгээний тэнхимээс НББ хөтөлбөрийн 3-р түвшний оюутнуудын дунд “Өртгийн бүртгэл” хичээлийн олимпиад зохион байгууллаа. Олимпиадад төв сургуулийн өдрийн ангийн 3-р түвшний 21, Дархан салбарын 3-р түвшний 5 нийт 26 оюутан оролцсон юм. Тус олимпиадыг Монгол Такс ТМЗ компани 12 дахь жилдээ ивээн тэтгэж доор оюутнуудыг 1-3 сарын цалинтай дадлага хийх эрхээр шагнаж урамшууллаа.

1-р байр НББ татвар хөтөлбөрийн 3-р түвшний оюутан **Б.Батчимэг**

2-р байр НББ татвар хөтөлбөрийн 3-р түвшний оюутан **А.Номиндарь**

3-р байр НББ банк хөтөлбөрийн 3-р түвшний оюутан **Э.Уянга**

Тусгай байр НББ эрх зүй хөтөлбөрийн 3-р түвшний оюутан **Б.Булган-Эрдэнэ**

Тусгай байр НББ эрх зүй хөтөлбөрийн 3-р түвшний оюутан **Х.Цээтогтох**

Тусгай байр Дархан салбар сургуулийн 3-р түвшний оюутан **Б.Болор**



ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ ГАРДАН АВЛАА.

Дэлхийн магадлан итгэмжлэлийн өдрийг тохиолдуулан Мандах их сургуулийн Ахисан түвшний сургуулийн “Бизнес удирдлага” болон “Санхүү” магистрын хөтөлбөрүүдийн үндэсний хэмжээний магадлан итгэмжлэлийн гэрчилгээг Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлөөс ёслол төгөлдөр гардуулан өглөө.

“Бизнес удирдлага” болон “Санхүү” магистрын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжилсэн тухай гэрчилгээг Сургалт эрхэлсэн проректор, доктор, профессор Ч.Төрбадрах, Ахисан түвшний сургуулийн захирал, доктор, дэд профессор О.Бурмаа нар нь хүрэлцэн очиж, гэрчилгээг хүндэтгэлтэйгээр хүлээн авлаа.



ХОС ДИПЛОМЫН ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСӨГЧИД ДИПЛОМОО ГАРДАН АВЛАА

Мандах их сургуулийн 2016 оноос Швейцарын Холбооны Улсын Эдийн засаг, технологийн их сургуультай хос диплом олгох хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Энэ жил уг хөтөлбөрийн 6 дахь төгсөлт болж, хөтөлбөрөө амжилттай дүүргэсэн 16 төгсөгчдөд 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдөр дипломыг гардуулах ёслол боллоо.

Тус хөтөлбөрөөр нийтдээ 70 шахам оюутан суралцаж, Мандах их сургууль болон Швейцарын Холбооны Улсын Эдийн засаг, технологийн их сургуулийн дипломыг тус тус гардан аваад байна.

Энэхүү хос дипломын хөтөлбөрөөр төгсөгчдийн англи хэлний мэдлэгийн түвшин сайжирдаг учир цаашид гадаадын их, дээд сургуульд магистраар элсэн суралцах болон гадаадын хөрөнгө оруулалттай компани, олон улсын байгууллагад эрдэм шинжилгээ болон мэргэжлээрээ ажиллах боломж зэрэг олон давуу талыг олгодог талаар ректор Г.Нанжид, проректор Ч.Төрбадрах, С.Энхтуяа нар ёслолын үеэр үг хэлэхдээ онцлон дурдаж, төгсөгч нартаа баяр хүргэн цаашдын ажил, амьдралд нь сайн сайхныг хүслээ.



БАКАЛАВРЫН НББ-ЭЧНЭЭ БОЛОН МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах Их Сургуулийн бакалаврын эчнээ болон магистрын хөтөлбөрийн төгсөлтийн үйл ажиллагаа 2024 оны 06 сарын 24-ний өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Ёслолын үйл ажиллагааг нээж мандах ИС-ийн ректор, гавьяат багш, профессор Г.Нанжид хөтөлбөрт хамрагдаж амжилттай суралцсан оюутнууд болон тухайн хөтөлбөрт хичээл заасан багш нарт баяр хүргэн, цаашдын ажил, хөдөлмөрт нь амжилт хүслээ. Үйл ажиллагаанд Мандах Их Сургуулийн удирдлага, Эрдмийн зөвлөлийн гишүүд оролцож, төгсөгчдөд амжилт хүсэж, диплом энгэрийн тэмдгийг гардуулж өглөө.

Энэ удаагийн төгсөлтөөр бакалаврын эчнээ хөтөлбөрийн 115 оюутан, Нягтлан бодох бүртгэл, Санхүү, Бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрөөр 16 магистрант төгслөө



МАНДАХ ИХ СУРГУУЛЬ НЬ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД 4 ДЭХ УДААГАА 10 ЖИЛЭЭР МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДЛЭЭ

Мандах их сургууль нь Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлөөр 4 дэх удаагаа 10 жилээр магадлан итгэмжлэгдсэн гэрчилгээгээ албан ёсоор ёслол төгөлдөр гардан авлаа. Түүнчлэн Мандах их сургуулийн Ахисан түвшний сургуулийн “Нягтлан бодох бүртгэл” магистрын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлсэн гэрчилгээгээ хүлээн авлаа.

Байгууллагыг болон хөтөлбөрийг магадлан итгэмжилсэн тухай гэрчилгээг Ректор, профессор Г.Нанжид, Ахисан түвшний сургуулийн захирал, доктор, дэд профессор О.Бурмаа нар нь хүрэлцэн очиж, гэрчилгээг хүндэтгэлтэйгээр хүлээн авлаа.



“Entrepreneurship training program” сургалтыг БНСУ-ын Чанвон хотод 2024 оны 3 сарын 25-30-ны өдрүүдэд хамтран зохион байгууллаа.

Мандах Их Сургууль нь БНСУ-ын International Institute of Management and Human Rights (IIMHR) байгууллагатай байгуулсан гэрээний дагуу “Entrepreneurship training program” сургалтыг БНСУ-ын Чанвон хотод 2024 оны 3 сарын 25-30-ны өдрүүдэд хамтран зохион байгууллаа. Энэхүү сургалтанд тус сургуулиас ерөнхий нягтлан бодогч Г.Эрдэнээ, СШУИТ-ийн ахлах багш М.Ганхөлөг, зохион байгуулагч-орчуулагчаар БШТ-ийн багш Э.Ундрал болон төрийн байгууллага, компаниудын төлөөлөл болох 8 хүн хамрагдлаа.

Сургалтын хүрээнд үйлдвэр, компаниудтай танилцах аялалаар Doosan Enerbility компанийн гангийн үйлдвэр, Daehan Steel компанийн хөгжүүлж буй шинэ тенологийн хүлэмжийн аж ахуй болон [VDream](#) старт ап компанийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судлав.



Мандах их сургууль болон Бүгд Найрамдах Казахстан Улсын Казах-Бритиш Техникийн их сургуулийн хооронд Хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.

Бүгд Найрамдах Казахстан Улсын Казах- Бритиш Техникийн их сургуулийн төлөөлөл 2024 оны 4-р сарын 16-ны өдөр Мандах их сургуульд айлчиллаа. Айлчлалын үеэр Хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурах ёслолын ажиллагаа боллоо.

Санамж бичгийн хүрээнд багш, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, богино хугацааны танилцах айлчлалыг зохион байгуулах, зочин багшийг урьж, лекц уншуулах, харилцан туршлагаа хуваалцах, эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хөтөлбөрийг хамтран боловсруулах, докторант оюутнуудын судалгааны ажлыг хамтран удирдах, хоёр орны үндэсний соёл, ёс заншлаас харилцан суралцах зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэх юм.



МАНДАХ ИХ СУРГУУЛЬ, БНСУ-ЫН ЧОНЖУ ИХ СУРГУУЛЬТАЙ ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭГ БАЙГУУЛЛАА

Мандах их сургууль Солонгосын Чонжү (Cheongju University) их сургуультай 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн, Мандах их сургуулийн бакалавр, магистр, докторын хөтөлбөрүүдэд суралцагчдыг 1, 2-р түвшин дүүргэсэн бол Чонжү их сургуульд үргэлжлүүлэн суралцуулах хамтарсан хөтөлбөр болон багш, оюутан солилцох, эрдэм шинжилгээ, судалгаа хийх зэрэг өргөн хүрээнд хамтран ажиллах гэрээг 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр байгууллаа.

Чонжү их сургуульд хамтарсан хөтөлбөрөөр суралцах оюутны эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 50% хөнгөлөх сайхан боломжийг Мандах их сургуулийн оюутнуудад олгохоор боллоо.

Гэрээнд хоёр талын ректорууд гарын үсэг зурж, баталгаажууллаа.

Гэрээ байгуулах үеэр Мандах их сургуулийн ректор Г.Нанжид: 100 жилийн түүхтэй Солонгосын шилдэг их сургуультай хамтран ажиллах болсон нь бидний цаашдын хөгжил дэвшил болон оюутан суралцагч нарт томоохон оюуны хөрөнгө оруулалт болно гэдгийг онцолсон бол Чонжү их сургуулийн ректор Ён Бай Ким “Мянга сонссоноос нэг удаа үз” гэсэн үг бий. Монголын сайхан оронд ирж, Мандах их сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулсандаа баяртай байна. Бидний хамтын ажиллагаа амжилттай хэрэгжинэ гэдэгт итгэлтэй байна гэж онцлон тэмдэглэлээ.



Түмэн торго компанитай ажлын байранд суурилсан сургалтыг амжилттай хэрэгжүүлж байна.

Түмэн торго ХХК нь Мандах Их сургуулийн оюутнуудыг “Ажлын байранд суурилсан сургалт”-ын хүрээнд хамтарсан хөтөлбөрөөр 4 оюутан, үйлдвэрлэлийн дадлагын хүрээнд 8 оюутан, цагийн ажилтнаар 6 оюутанг тус тус авч ажиллуулж байна.

Хамтарсан арга хэмжээний зорилго нь:

1. Ажлын байранд дөнгөж дасаж байгаа оюутан залуусыг урамшуулах, ажлын байрыг илүү сонирхолтой болгох
2. Оюутнуудтай ажиллаж байгаа багш нарыг онолын мэдлэгээс гадна практик мэдлэг, мэдээлэл өгөх
3. Цаашид хоёр талаас авч хэрэгжүүлэх ажлууд, сайжруулалт зэргийг ярилцаж, ойлголцох байлаа.

Арга хэмжээний үеэр “Ажлын байранд суурилсан сургалт”-аар ажиллаж байгаа 4 оюутанг Түмэн Торго ХХК-ийн Захирал Б.Очирням Жинин-Хөх хот явах аялалын эрхийн бичгээр шагнахаас гадна мөн 4 оюутанг шагнаж урамшууллаа. Хамтарсан арга хэмжээнд Мандах Их сургуулиас Сургалт эрхэлсэн проректор Ч.Төрбадрах, Бүртгэл шинжилгээний тэнхимийн эрхлэгч Д.Цэвэлмаа, Бүртгэл шинжилгээний тэнхимийн багш Ц.Номин нар оролцлоо.



МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СУРГУУЛЬ “СМАРТ ЛОЖИК” ХХК-ТАЙ ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭГ БАЙГУУЛЛАА

Бид Enterprise-программ хангамжийн зах зээлд Монголдоо №1 компани болох алсын хараатай СМАРТ ЛОЖИК ХХК-тай 2024.06.14-ны өдөр түншлэлийн гэрээг байгууллаа. Гэрээний зорилго нь Мандах Их Сургуулийн оюутнуудыг онолын мэдлэгээ бататгах, бүх төрлийн мэргэжлийн дадлага хийлгэн, мэргэжлийн дагуу ажиллах чадвар дадал эзэмшүүлэх болон ажилтнаар сонгон авч ажиллуулахад чиглэгдэх юм.

Хамтын ажиллагааг эхлүүлснээр Мандах их сургуульд суралцаж буй оюутнуудад Smart ERP системийн программыг албан ёсоор хичээлийн хүрээнд судлах, СМАРТ ЛОЖИК компанид дадлагажих, төгсөөд ажлын байраар хангах гэх мэт олон боломжууднээгдэж байна.



Мандах Их сургууль, Голомт банктай хамтарсан ажлын байранд суурилсан хөтөлбөр амжилттай болж өндөрлөлөө

Мандах Их Сургууль нь Голомт банктай хамтын ажиллагааны хүрээнд “Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөр”-т 2023 оны 10 сараас 2024 оны 03 сар хүртэл нийт 6 сарын хугацаанд 42 оюутанг хамруулсан. Уг хөтөлбөрийн онцлог нь 4-р түвшний оюутнууд нь Голомт банкны ажлын байранд үндсэн ажилтнаар ажиллаж, цалинтай дадлагажих хөтөлбөрт оролцсон. Хөтөлбөрийн хугацаанд оюутнууд онолын мэдлэгээ практикаар эзэмшиж, олон улсын сургалт, семинаруудад хамрагдаж, өөрийн хийсэн ажлаар 2 удаагийн тайлангаа хэлэлцүүлсэн болно. Уг хөтөлбөрийн гол онцлог нь оюутнууд цалинтай ажиллангаа сургууль дээрээ нийт 20кр-ийг дүйцүүлсэн ба онолын мэдлэгээ практикт хэрэгжүүлж, аливаа байгууллагад ажилд ороход шаардагдах анхан шатны ур чадварыг эзэмшиж, мэргэжлийн чиг баримжаа авахаас гадна хувь хүний хөгжилдөө ахиц дэвшил гаргах боломжтой болсон юм.

Хагас жилийн хугацаанд үргэлжилсэн уг хөтөлбөрт хамрагдсан оюутнуудад Голомт банкны Хүний нөөцийн удирдлагын газрын захирал Г.Уянга, Мандах их сургуулийн Сургалт эрхэлсэн проректор Ч.Төрбадрах, Голомт банкны ХНУГ-ын Үйл ажиллагааны хэлтсийн захирал Д.Оюу, Мандах их сургуулийн Эдийн засаг, бизнесийн тэнхимийн эрхлэгч Б.Сайнжаргал нар оюутнуудад батламж гардууллаа.



Нягтлан бодох бүртгэлийн сургууль болон KPMG Аудит компани хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа

Мандах Их Сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн сургууль нь KPMG Аудит компанитай хамтран ажиллах гэрээ байгуулав. Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн захирал Х.Нямбаяр, KPMG Аудит ХХК-ийн ерөнхий захирал Г.Соёлмаа нар хамтын ажиллагааны гэрээнд 2024.05.02-ны өдөр гарын үсэг зурлаа. Тус хамтын ажиллагааны хүрээнд харилцан сургалт явуулах, Мандах Их Сургуулийн НББ-ийн хөтөлбөрийн оюутнуудыг танилцах болон үйлдвэрлэлийн дадлагад гаргах болон бусад чиглэлээр хамтран ажиллах юм.

Энэ үеэр KPMG Аудит компанийн хүний нөөцийн менежер П.Алтанзул, эрсдэлийн удирдлага хариуцсан дэд захирал Б.Тунгалагтуяа нар 3 болон 4-р түвшний оюутнуудад зориулж, KPMG Аудит компанийн үйл ажиллагааны танилцуулга, аудиторын карьерын туршлага, цаашдын боломжийн талаар сонирхолтой илтгэл тавилаа.



**“СУДЛААЧ ОЮУТАН-2024” ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ V БАГА ХУРАЛ
АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА**

Мандах Их Сургуулиас уламжлал болгон зохион байгуулдаг үндэсний хэмжээний “СУДЛААЧ ОЮУТАН-2024” эрдэм шинжилгээний бага хурал 5 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр суралцаж буй оюутнуудыг судалгаа шинжилгээний ажилд дадлагажуулах, практик дадлага олгох, бие даан шийдвэр гаргах чадвар эзэмшүүлэх, эрдэм шинжилгээний ажлыг урамшуулан дэмжсэнээр оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилготойгоор 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийг дуустал хоёр үе шаттайгаар зохион байгуулагдлаа. Хуралд ШУТИС, МУИС, ХААИС, Мандах Их Сургууль, СЭЗИС, ИЗОУИС, ОУУБИС, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль зэрэг нийт 8 сургуулийн 79 оюутны 44 илтгэл бүртгүүлсэнээс I шатны шалгаруулалтад хамтарсан болон ганцаарчилсан байдлаар оролцсон 54 оюутны 30 илтгэл тэнцэж II шатны үндсэн хэлэлцүүлэгт орсон байна. Үндсэн хэлэлцүүлэг 2024 оны 05 дугаар сарын 07-нд Мандах Их Сургуулийн С байрны №513, №514 тоот хурлын танхимд болж өндөрлөлөө. Эрдэм шинжилгээний хурлыг Мандах Их Сургуулийн Сургалт эрхэлсэн проректор, доктор(Ph.D), профессор Ч.Төрбадрах нээж үг хэллээ.

Салбар хуралдаан 1: Эдийн засаг, Санхүү, Банк, Нягтлан бодох бүртгэл

Хурлын шүүгчдийн бүрэлдэхүүн:

- Ерөнхий шүүгч: СЭЗИС-ийн СШУТ-ийн профессор, доктор(Ph.D) Ч.Наранчимэг
- MCS интернейшнл, Ерөнхий нягтлан Н.Пүрэвдулам
- Мандах Их Сургуулийн Бүртгэл Шинжилгээний Тэнхимийн эрхлэгч Д.Цэвэлмаа

Мандах Их Сургуулийн Эдийн засаг, Бизнесийн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D) Б.Оюунсүрэн

Салбар хуралдаан 2: Бизнесийн удирдлага, Маркетинг, Нийгмийн ухаан

- Ерөнхий шүүгч: доктор(Ph.D), дэд профессор Б.Оюунтунгалаг
 - MCS интернейшнл, Хүний нөөцийн менежер
 - Мандах Их Сургуулийн, Ахисан түвшний сургуулийн захирал, доктор (Ph.D) О.Бурмаа
 - Мандах Их Сургуулийн Эдийн засаг, Бизнесийн тэнхимийн эрхлэгч, доктор(Ph.D) Б.Сайнжаргал
- Мандах Их Сургуулийн Эдийн засаг, Бизнесийн тэнхимийн ахлах багш, доктор(Ph.D) Т.Ганхуяг

II шатны сонгон шалгаруулалтад 54 оюутны 30 илтгэл шалгарсан бөгөөд салбар чиглэлээр нь ангилж 2 салбар хуралдаан болгон хуваалаа. Шагналт байранд үүнээс шилдэг 6 илтгэлийг шалгаруулсан.

Эрдэм шинжилгээний хурлын ивээн тэтгэгч байгууллагаар MCS интернэйшнл, Techpack байгууллагууд хамтран ажиллаа. Мөн уг хурлын үеэр Мандах Их Сургуулийн оюутнуудад тусгайлан зориулж ажлын байрны нээлттэй өдөрлөгийг зохион байгууллаа.

Хурлын үйл ажиллагааг ивээн тэтгэн ажилласан MCS интернэйшнл, Techpack байгууллагын хамт олонд талархлаа илэрхийлэе.

Эрдэм шинжилгээний хурлын шүүгчдийн бүрэлдэхүүнд ажилласан Мандах Их Сургуулийн профессор багш нар, ерөнхий шүүгчээр ажилласан ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн доктор(Ph.D), дэд профессор Б.Оюунтунгалаг, СЭЗИС-ийн СШУТ-ийн профессор, доктор(Ph.D) Ч.Наранчимэг мөн MCS интернэйшнл, Techpack байгууллагын төлөөлөгч нарт талархал илэрхийлэе.



МАНДАХЧУУД НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН УЛСЫН 25-Р ОЛИМПИАДАД БАГИЙН ДҮНГЭЭР ДЭД БАЙР ЭЗЭЛЛЭЭ.

Мандах Их сургуулийн Э.Энх-Амгалан (МНБ), Г.Золбоо (МНБ), С.Цэвээнжаргал (МНБ) багшаар удирдуулсан баг дэд байр, Мандах Их сургуулийн Дархан салбар сургуулийн А.Шижирбаатар (МНБ), Б.Мөнхбаяр (US CPA, CMA), Х.Одмандах багшаар удирдуулсан баг гутгаар байранд орсон амжилтыг үзүүлээ.

Овог	Нэр	Анги	Эзэлсэн
Пунцагдулам	Маралгоо	НББ-Аудит 4-р түвшин	1
Бямба-Эрдэнэ	Булган-Эрдэнэ	НББ-Эрх зүй 3-р түвшин	6
Хатанбаатар	Цолмон-Эрдэнэ	НББ-Мэдээллийн систем 3-р	7
Болортуяа	Бат-Эрдэнэ	НББ-Банк 4-р түвшин	8
Батсайхан	Энхбаясгалан	НББ-Татвар 4-р түвшин	10

Мандах Их сургуулийн Дархан салбар сургуулийг төлөөлж оролцсон оюутнуудын мэдээлэл:

Овог	Нэр	Анги	Эзэлсэн байр
Лувсаншарав	Ган-Эрдэнэ	НББ-Аудит 4-р түвшин	3
Баасандамба	Номундарь	НББ-Аудит 2-р түвшин	7
Эрдэнэцэцэг	Өлзийбаяр	НББ-Аудит 4-р түвшин	8
Батбаатар	Болор	НББ-Аудит 3-р түвшин	8
Эрдэнэ-Очир	Энх-Оргил	НББ-Аудит 4-р түвшин	



СТАТИСТИКИЙН УЛСЫН V ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

Монгол улсад Статистикийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтан зохион байгуулж буй Мандах Их Сургуулийг үүсгэн байгуулагч Б.САНДАГСҮРЭНГИЙН нэрэмжит СТАТИСТИКИЙН УЛСЫН V ОЛИМПИАД 2024 оны 4 сарын 27-нд болж өндөрлөлөө. Тус олимпиадад 5 сургуулийн 50 гаруй оюутнууд ганцаарчилсан болон багийн төрлөөр өрсөлдлөө. Мандах Их сургуулийн багш Н.Далайсайхан, С.Анхбаяр нараар удирдуулсан оюутнууд ганцаарчилсан төрөлд шагналт 10 байраас 6-н байрыг эзэлж тэргүүн байр, багийн төрөлд дэд байр эзэлсэн амжилт үзүүллээ. Багийн төрөлд :

I байр Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

II байр Мандах Их сургууль

III байр МУИС- Мэдээллийн Технологи Электроникийн сургууль шалгарлаа.

Ганцаарчилсан төрлийн шагналт 10 байранд орсон оюутны нэрс

Байр	Овог	Нэр	Сургуулийн нэр	Түвшин
I	Буянхүү	Баяртуул	Мандах их сургууль	НББ-Банкны 2-р түвшин
II	Гантулга	Дөлгөөннара	Мандах их сургууль	НББ-Аудитийн 2-р түвшин
III	Метлица	Давааням	СЭЗИС	Санхүү удирдлагийн 2-р
IV	МөнхЭрдэ	Лхагвасүрэн	Мандах их сургууль	НББ-Аудитийн 2-р түвшин
V	Ганхуяг	Мөнхчимэг	Мандах их сургууль	НББ-Банкны 2-р түвшин
VI	Нямжав	Номин	Мандах их сургууль	НББ-Аудитийн 2-р түвшин
VII	Ганбат	Алимансаран	Мандах их сургууль	НББ-Банкны 2-р түвшин
VIII	Батчулуун	Эрдэнэ-Очир	СЭЗИС	Санхүү удирдлагийн 2-р
IX	Баттулга	Номун	СЭЗИС	НББ-н 2-р түвшин



Шагнал урамшуулал

Доржсүрэнгийн Бадарч АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ АЖИЛТАН ЦОЛ -оор шагнууллаа

Мандах их сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, ЭЗБТ-ийн зөвлөх профессор, доктор Доржсүрэнгийн Бадарч Хөнгөн аж үйлдвэрийн салбарын 90 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ АЖИЛТАН ЦОЛ -оор шагнагдсанд сургуулийн захиргаа, хамт олны зүгээс баяр хүргэж, цаашдын ажил, амьдралд нь амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.



Монгол Инженер-2024 нэгдсэн арга хэмжээ зохион байгуулагдаж манай сургууль амжилттай оролцлоо.

“Монгол Инженер -2024” нэгдсэн арга хэмжээ Эрдэм шинжилгээний хурал, CAD CAM CAE олимпиад, Техникийн механикийн олимпиад гэсэн үндсэн 3 чиглэлээр 2024 оны 24, 26, 27-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд нийт 12 их дээд сургууль, коллежийн багш оюутнууд болон, үйлдвэр албан байгууллагын инженер техникийн ажилчид нийт 300 гаруй хүн оролцож оюун ухаан мэдлэг чадвараа сорин уралдлаа. Мандах Их Сургуулиас тус арга хэмжээнд багийн болон ганцаарчилсан төрлүүдээр анх удаа оролцож Техникийн механикийн олимпиадын “Механизмын дизайн” хичээлийн төрөлд хувийн ажилтаар ИЭЗ-4 ангийн оюутан Д.Шугар 3-р байранд шалгарсан амжилт гаргалаа.



“Мандах Мазаалай” сагсан бөмбөгийн эмэгтэй шигшээ баг Монголын оюутны лигийн 2023-2024 оны “Division 2”-ийн МӨНГӨН МЕДАЛИЙН эзэд боллоо

Мандах их сургуулийн Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхимийн багш А.Даваадорж дасгалжуулагчтай М. Нандин-Эрдэнэ ахлагчтай Сагсан бөмбөгийн “Мандах Мазаалай” эмэгтэй шигшээ баг Монголын оюутны лигт 2022-2023 оны “Division 2”-д анх удаа оролцож 4-р байрт орсон амжилт гаргасан.

Монголын оюутны лигийн 2023-2024 оны “Division 2”-д Мандах Мазаалай Сагсан бөмбөгийн эмэгтэй шигшээ баг тамирчид, өнгөрсөн жилийн амжилтаа ахиулан “МӨНГӨН МЕДАЛЬ”-ын шагнал хүртлээ.



2024 оны 05 сарын 10, 11 өдрүүдэд "Залуу Санхүүчдийн Холбоо"-ноос Санхүү Менежментийн Улсын Х олимпиад зохион байгуулагдлаа

2024 оны 05 сарын 10, 11 өдрүүдэд "Залуу Санхүүчдийн Холбоо"-ноос Санхүү Менежментийн Улсын Х олимпиад зохион байгуулагдлаа. Энэ удаагийн Санхүүгийн Менежментийн Улсын Х дугаар олимпиадад 8 их, дээд сургуулийн 13 багийн шилдэг 65 оюутан 2 үе шаттайгаар санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр тест болон кейс даалгаврын ажлыг гүйцэтгэсэн. Энэхүү улсын олимпиадад Мандах Их Сургуулийн "Blades" баг болох санхүү менежментийн хөтөлбөрийн 3-р түвшний оюутан Ц.Оюун-Эрдэнэ, Д.Дагвасүмбэрлэн, М.Энххүслэн; 4-р түвшний оюутан болох Ө.Энхжаргал, Б.Мөнхсүвд нар "Тусгай байр"-нд шалгарсан амжилттай оролцлоо



Нийгмийн хариуцлага

Мандах ИС “Малчдадаа туслах” хандивын аян зохион байгууллаа.

Мандах Их Сургууль нийгмийн хариуцлагын хүрээнд цаг агаарын хүнд, давагдашгүй хүчин зүйлд нэрвэгдсэн малчид, ард иргэддээ тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор, сургуулийн багш ажилтнууд, төгсөгчид, оюутан залуус нэгдэж хандивын аянд оролцлоо.

Байгалийн гамшигт хүндрэл, бэрхшээлд байгаа малчин түмэндээ туслах сэтгэлийн хандивыг өрнүүлэн Мандах их сургуулийн, Мэдээлэл технологийн сургууль, Мандах Лицей ахлах сургууль болон Мандах ИС нийт хамт олноос 5 сая төгрөгийн хандивыг цуглуулан өвөлжилт хүндэрсэн Төв аймгийн Алтанбулаг суманд UBS телевизээс зохион байгуулж буй малчдадаа туслах хандивын аянд нэгдэж малчны хотонд хүргүүлээ.



“Ахисан түвшний сургууль, нягтлан бодох бүртгэлийн сургуулийн нэрэмжит” магистр болон эчнээ хөтөлбөрийн суралцагчдын дундах спортын 4 төрөлт тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа

Ахисан түвшний сургууль, нягтлан бодох бүртгэлийн сургуулийн нэрэмжит” магистр болон эчнээ хөтөлбөрийн суралцагчдын дундах спортын 4 төрөлт тэмцээн 2024 оны 03-р сарын 24-ний өдөр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Энэхүү тэмцээнд нийт 11 баг тамирчид сагсан бөмбөг, гар бөмбөг, теннис, дартс гэсэн 4 төрлөөр тамирчдын хурд хүч авхаалж самбааг сорин өрсөлдлөө. Тэмцээнийг нээж Мандах их сургуулийн ректор МУ-ын Гавьяат багш, профессор Г.Нанжид нээж үг хэллээ.

Сагсан бөмбөгийн төрөлд

1. Багш нарын баг
2. НББ-ийн Эчнээ 1-2
3. НББ-ийн Эчнээ 2-4

Дартсын төрөлд

1. НББ-ийн Эчнээ 1-3
2. НББ-ийн Эчнээ Өмнөговь
3. НББ-ийн Эчнээ 1-4

Гар бөмбөгийн төрөлд

1. НББ-ийн Эчнээ 1-4
2. НББ-ийн Эчнээ 2-1
3. Багш нар

Теннис төрөлд

1. НББ-ийн Эчнээ 1-3
2. НББ-ийн Эчнээ Өмнөговь
3. Магистр Өвөл-1



Магистр болон эчнээ хөтөлбөрийн суралцагчдын тэмцээний нийлбэр дүнгээр НББ-ийн Эчнээ 1-3 хөтөлбөрийн хамт олон тэргүүн байр “Шилжин явах цомын эзэн”-ээр тодорлоо.

Нягтлан Бодох Бүртгэлийн Авхаалж Сорих Тэмцээн зохион байгуулагдлаа

НББ-ийн сургуулийн БШТ нь 1998 оноос эхлэн жил бүр НББ-ийн хөтөлбөрийн 3-р түвшний ангиудын дунд “НББ-ийн АСТ”-ийг зохион байгуулсаар ирсэн. 27 дахь удаагийн АСТ нь 3-р сарын 22, 25-ны өдрүүдэд 2 үе шаттайгаар амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд НББ-ийн хөтөлбөрийн 7 ангийн нийт 6 баг оролцлоо. Багууд 1-р шатанд 5, 2-р шатанд 7 нийт 12 төрлийн тэмцээнээр өрсөлдөж, шилдэгүүдээ шалгарууллаа:

1-р байр: НББ-МС-3 ангийн түвшин

2-р байр: НББ-Банк-3 ангийн түвшин

3-р байр: НББ-Татвар-3 түвшин

Энэ жилийн АСТ нь бүх тэмцээнийг танхимд зохион байгуулж амьд харилцааг эрхэмлэсэн, мөн Мандах Их Сургууль 2023-2024 оны хичээлийн жилийг “Чанар, Ёс зүй, Хариуцлага”-ын жил болгон зарласантай холбоотойгоор “Мэргэжил ба ёс зүй” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсанаараа онцлог байлаа.



Редакцийн зөвлөл:

Ч.Төрбадрах /Сургалт эрхэлсэн проректор /
И-мэйл: turbadrakh@mandakh.edu.mn

Г.Энхжин/ Санхүү аж,ахуйн алба/
И-мэйл: Enkhjin@mandakh.edu.mn